

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Эмэгтэйчүүдэд нөлөөлж буй гадны гай зовлонгийн төлөөх залбирал

Бид амьдралынхаа бүхий л хугацаандаа заримдаа гэнэтийн, огцом өөрчлөлтүүдтэй нүүр тулдаг. Гэрлэлт, жир эслэлт гээд аз жаргалтай өөрчлөлтүүд байдаг ч мөн айдас дагуулсан, тогтворгүй өөрчлөлтүүд чолноор гарч ирдэг. Өнөөдөр ч гэсэн тоолж баршгүй олон эмэгтэй дайн, байгалийн гамшиг, ядуурал зэргээс болж нэг шөнийн дотор аюулгүй, тухтай амьдралаа алдаж, айдас, зовлон дунд амьдарсаар байна. Өнөөдөр бид тэдний төлөө хамтдаа залбирч, итгэлийн дулаан гараа сунган, жижиг үйлдлээр ч бодит тусламж үзүүлэх нь танд ямар санагдаж байна вэ? Бидаз жаргалтай болон зовлонтой мөчүүддээ хэзээ ч ганцаараа байдаггүй. Учир нь Би баруун гараас чинь атгах Чиний Бурхан ЭЗЭН билээ. Би чамд «Бүү ай. Би чамд тусална» гэж айлдаж байна. (Исаиа 41:13)



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

орны гэр бүлүүдийн хэрэгцээг хангаж өгөөч. (Дуулал 23:1)

4. Эзэн минь, Бонэйр аралд ирсэн цагаачдад амьдрах сайн боломж, нийгмийн хүлээн зөвшөөрлийг хайрлаач. (Еврей 13:2)

5. Бурхан минь, Ботсвана улсын шинэ удирдлагыг залж чиглүүлэн, улс орны дэг журмыг сэргээж, өмнөх удирдагчдын авлигын асуудлыг шударгаар шийдвэрлэхэд нь туслаач. (Даниел 2:21)

6. Аав аа, Камбож улсын олон иргэд эдийн засгийн хямрал, ажилгүйдлээс болж гэр бүлээ орхин хууль бус ажил эрхлэхээр гадаад руу явж байна. Тэдэнд тогтвортой ажил олоход нь туслаач. (Дэд хууль 24:14)

7. Эзэн минь, Канадын Христэд итгэгчдийг дүрвэгсдийн үйлчлэлд идэвхтэй оролцон, хүнд нөхцөлд байгаа эмэгтэй дүрвэгсдэд болон шинэ суурьшигчдад туслах сэтгэлийг өгөөч. (Дэд хууль 10:18-19)

8. Эзэн минь, Төв Африкийн Бүгд Найрамдах Улсын засгийн газрын авлигыг үндсээр нь устгаж, ард иргэдийнх нь зовлонг нимгэлээч. (Дэд хууль 16:19)

9. Бурхан минь, Хятад улсад хүн амаа хангалттай хүнсээр хангахуйц газар нутаг хүрэлцэхгүй байна. Тус улсын удирдагчдад хүнсний аюулгүй байдлыг хангах мэргэн ухаан хайрлаач. (Сургаалт үгс 2:6)

10. Израиль, Газын зурвас дахь нөхцөл байдлыг өргөн залбирч байна. Аав аа, энэ нутагт амар амгаланг тогтоож, гэмгүй хүмүүсийг эдгээж, зовж буй хүмүүсийг авраач. (Иохан 16:33)

11. Эсватини улсын хаан ядуурал, ажилгүйдлийн түвшин 35.4% хүрсэн нь үндэсний хэмжээний гамшиг болсон гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Удирдагчдад ажлын байр бий болгож, иргэддээ ур чадвар олгоход нь мэргэн ухаан хайрлаач. (Иаков 1:5)

12. Бурхан минь, дайны хүнд хэцүү нөхцөлд зовж буй хүмүүст урам зориг, тайвшрал, хэрэгтэй мэдээлэл өгдөг "Найдвар доторх эмэгтэйчүүд" багийн Украин, Оросын багийнхныг хүч чадал, мэргэн ухаанаар дүүргээч. (Дэд хууль 31:8)

1. Эзэн минь, дэлхий даяарх улс төрчдийн мөс чанарыг сэргээж, хүний наймааны гэмт хэрэг үйлдэгчдэд хуулийн хатуу хариуцлага тооцдог болгооч. (Дуулал 82:4)

2. Бурхан минь, Албани улсын эдийн засгийн хүндрэлээс болж олон залуус эх орноо орхин, Герман, АНУ руу дүрвэхийг илүүд үзэж байна. Тэдэнд эх орондоо үлдэх боломжийг нээж өгөөч. (Леви 19:33-34)

3. Энэрэнгүй Аав минь, дайн болон улс төрийн хурцадмал байдлаас болж орон гэргүй болсон Бенин болон дэлхийн олон

13. Тэнгэрлэг Аав минь, Индонезийн гамшигт өртөмтгий бүс нутгийн оршин суугчдыг гамшгийн үед хамгаалж, аюулгүй байртай байлгаач. (Дуулал 31:2)

14. Японы хүн ам өндөр насалж, цөөрснөөс эдийн засаг нь доройтож байна. Эзэн минь, тус улсын ард иргэдийг таны зүг харж, эдийн засгийн шийдэл олоход нь туслаач. (Дуулал 105:4)

15. Аав аа, Өмнөд Солонгосын сүмийн гишүүдийг тус улсад амьдарч буй 2.5 сая гадаадын иргэдэд сайн мэдээ түгээхэд идэвхтэй болгооч. (Марк 16:15)

16. Эзэн минь, Либери улсын хөдөлмөр эрхлэлтийн шударга бус байдлыг арилгаж, ард иргэд нь хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэх боломжтой болгооч. (Номлогчийн үгс 3:13)

17. Эзэн минь, Мали улсын гудамжны хүүхдүүдийг аюулаас хамгаалж, тэднийг халамжилж, амьдралын боломж олгох насанд хүрэгчдийг илгээгээч. (Сургаалт үгс 31:8-9)

18. Эзэн минь, Монгол Улсын засгийн газрын авлигыг устгаж, удирдагчдыг зөв шударга байдлыг өгч, Танаас эмээн хүндэтгэхэд Та туслаач. (Мика 6:8)

19. Эзэн минь, Мьянмар дахь хүчирхийлэл зогсож, улс төр, энхийн яриа хэлэлцээ өрнөн, энх тайван, эв нэгдэл тогтох болтугай. (1 Коринт 1:10)

20. Аав аа, дайны талбарт байгаа нөхрүүдээ санаа зовнин хүлээж буй эхнэрүүдийг таны оршихуй тайвшруулж, зоригжуулаг. (Дуулал 55:22)

21. Эзэн минь, Нигерийн удирдагчдад ядуурлыг бууруулах, аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах мэргэн ухаан хайрлаач. (Сургаалт үгс 21:1)

22. Бурхан минь, Хойд Кавказын ард түмэнд сайн мэдээг түгээж буй илгээлтийн эздийг хүчирхэгжүүлж, адислаач. (Матай 28:19)

23. Эзэн минь, Папуа Шинэ Гвинейн удирдагчдад ариун цэврийн дэд бүтцийг сайжруулах шийдлийг олоход нь туслаач. (3 Иохан 1:2)

24. Бурхан минь, Парагвайд ядууралд өртсөн эмэгтэйчүүдийг эдийн засгийн тогтвортой байдал, хөгжилд хүргэх дэмжлэгийн сүлжээ бий болгооч. (Матай 5:42)

25. Аав аа, шашны хэт даврагчид болон антисемит үзэлтнүүдийн зүрхийг өөрчлөн, тэднийг танд ойртуулж өгөөч. (Иохан 6:44)

26. Эзэн минь, Өмнөд Африкт ядууст туслах төслүүд, бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлж, ядуу эмэгтэйчүүдийг тогтвортой орлоготой болоход туслаач. (Сургаалт үгс 19:17)

27. Төгс хүчит Эзэн минь, Танзанийн Няругусугийн дүрвэгсдийн хуаранд байгаа "Найдвар доторх эмэгтэйчүүд" нэвтрүүлгийн сонсогчдод Библи, радио, оёдлын машин гэх мэт хэрэгцээг хангаж өгөөч. (Филиппой 4:6)

28. Эзэн минь, Тимор-Лестегийн эдийн засгийг тогтворжуулж, хөгжүүлэн, ажлын байр нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах мэргэн ухаан өгөөч. (Иеремиа 29:11)

29. Тэнгэрлэг Аав минь, Уругвайд байгалийн гамшигт нэрвэгдсэн, хайртай хүмүүсээ алдаж, эд хөрөнгөөрөө хохирсон хүмүүст нигүүлслээ үзүүлээч. (Иов 1:21-22)

30. Эзэн минь, Вьетнамд Супер Хар салхи Ягигаас хохирсон хүмүүсийн амьдралыг сэргээхэд шаардлагатай нөөцийг арвижуулж өгөөч. (2 Коринт 9:8)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Сүм чуулган, итгэгчдийн өсөлт – Монголын сүм чуулганууд өсөж, итгэгчид итгэлээрээ гэрэл болон амьдарч, сайн мэдээг түгээхэд зоригтой байх болтугай. (Матай 5:14-16)
2. Архидалт, хар тамхи, гэмт хэргийн эсрэг – Монголын ард түмнийг архидалт, хар тамхи, хүчирхийлэл, гэмт хэргээс хамгаалж, залуу үеийг эрүүл, зөв замаар хөтөлж өгөөч. (1 Коринт 6:19-20)
3. Гадаадад ажиллаж, амьдарч буй монголчууд – Гадаадад байгаа монголчуудыг хамгаалж, тэднийг зөв хүмүүсээр хүрээлүүлж, эх оронтойгоо холбоотой байхад нь туслаач. (Дуулал 121:8)
4. Радио хөтөлбөрийн нөлөө – Энэ хөтөлбөр дамжигдах бүхий л газарт хүмүүсийн зүрх сэтгэлд хүрч, тэдэнд урам зориг, итгэл найдвар өгч байг. (Исаиа 55:11)
5. Сонсогчдын зүрх сэтгэлийн төлөө – Радио хөтөлбөрийг сонсож буй хүмүүсийн зүрхийг нээж, тэдэнд амьдралыг өөрчлөх мэргэн ухаан, итгэл найдвар өгөөч. (Езекиел 36:26)

Хувилган

**국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.**